

**“МЕРЕКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4-р сарын 27-ны өдөр

№ ХЭХ16/01

Улаанбаатар хот

Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан болон түүнд хийгдсэн хараат бус аудитын тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухайд

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Мерекс” ХК-ийн 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч **БАТАЛСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

**“МЕРЕКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4-р сарын 27-ны өдөр

№ ХЭХ16/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны
зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дэх заалт “Мерекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг хавсралтаар нийт 25,100,000 төгрөгөөр БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

“Мерекс” ХК-ийн 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
ХЭХ16/02 Тогтоолын хавсралт

“МЕРЕКС” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2016 оны зардлын төсөв /төгрөгөөр/

№	Зардлын нэр	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1	ТУЗ-ийн даргын цалин	400,000	6	2,400,000
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин	300,000*8	6	14,400,000
3	ТУЗ-ийн НБД-ын цалин	400,000	6	2,400,000
4	ТУЗ-ийн хурлын зардал	150,000	6	900,000
5	Томилолтын зардал	500,000	9	4,500,000
6	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	500,000	1	500,000
НИЙТ ДҮН				25,100,000

Тайлбар:

Мерекс ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалинг биечлэн болон цахим байдлаар хуралд оролцсон ирцийг харгалзан олгоно.

**“МЕРЕКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4-р сарын 27-ны өдөр

№ ХЭХ16/03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах заалт, “Мерекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр СОНГОСУГАЙ:

Ердийн гишүүдэд:

- Н.Улаанхүү
- М.Мөнхзолбоо
- М.Ундрал
- Ч.Жаргал
- Б.Хуяг
- Д.Баттулга

Хараат бус гишүүдэд:

- Н.Ичинхорлоо
- Г.Галбадрах
- Н.Өлзийхишиг

2. Компанийн үр ашигтай ажиллагааг хууль журмын дагуу удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ